



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/98

Арвайхээр сум

Эрх шилжүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сангийн сайдын төсвийн багц дахь төсөл арга хэмжээний бэлтгэл хангах зардлаас шилжин ирсэн 30,000,000 (гучин сая) төгрөгийн дэмжлэгийг төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор шаардлагатай байгаа техник, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд зориулан хавсралтад тусгагдсанаар зарцуулсугай.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, үр дүн, хэрэгжилтийг тайлагнахыг холбогдох сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0152

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны дугаар
сарын ны өдрийн дүгээр
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг (мян төг)
1	Төгрөг суманд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд хэрэглэгдэх техник, тоног төхөөрөмжийн зардалд	15,000.0
2	Есөнзүйл сумын төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд хэрэглэгдэх техник, тоног төхөөрөмжийн зардалд	15,000.0
	НИЙТ ДҮН	30,000,0

-оОо-